**МОНГОЛ УЛСЫН**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН**
**ТУШААЛ**

2021 оны 12 сарын 31 өдөр Дугаар А/816 Улаанбаатар хот

"Харшлаас сэргийлэх" арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Харшлаас сэргийлэх" арга хэмжээг 2021-2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг нэгдүгээр, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар тус тус батлалсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газар (Д.Баярболд), Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар (Ж.Нарангэрэл) Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Д.Нарантуяа)-д тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангах ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, төр, хувийн хэвшлийн бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг жил бүр төсөвт тусган ажиллахыг Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газар (Б.Мөнхтуул), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т тус тус даалгасугай.

САЙД С.ЭНХБОЛД

141213557

Эрүүл мэндийн сайдын 2021 оны
12... дугаар сарын 31 өдрийн А/816 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

# "ХАРШЛААС СЭРГИЙЛЭХ" АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

**Зорилго:** Харшлын эрсдэлт хүчин зүйлсийг бууруулан, урьдчилан сэргийлэлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах замаар харшлын шалтгаант өвчлөл, түүний хүндрэлийг бууруулах

**Зорилт:**
1. Харшлаас сэргийлэхэд чиглэсэн бодлого, эрх зүйн орчинг боловсронгуй болгох
2. Харшлын эрсдэлт хүчин зүйлсийг бууруулж, хүн амын мэдлэгийг дээшлүүлэх
3. Харшлын өвчний оношилгоо, эмчилгээний менежментийг боловсронгуй болгож, хүндрэлээс сэргийлэх
4. Харшлын өвчлөлийн бүртгэл, тандалтын тогтолцоо бий болгох

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хүрэх үр дүн | | | | Хариуцах байгууллага | Хамтрах байгууллага | Төсөв (сая) |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2021 он | 2022 он | 2023 он | 2024 он | | | |
| **Зорилт 1.**<br>**Харшлаас сэргийлэхэд чиглэсэн бодлого, эрх зүйн орчинг боловсронгуй болгох** | | | | | | | | |
| **Үйл ажиллагааны чиглэл 1.1.**<br>Харшлаас сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлсийг бууруулахад хэрэглэх заавар журмыг шинэчлэх | | | | | | | | |
| 1.1.1 | Суурьшлын бүсийн ногоон байгууламжид ашиглах ургамлын талаар заавар боловсруулж, орон нутгийн шийдвэр гаргагч нарт ухуулга нөлөөллийн ажил зохион байгуулах | Хамтарсан ажлын хэсэг байгуулсан байна. | Заавар боловсруул-сан байна. | Орон нутгийн шийдвэр гаргагч нарт ухуулга нөлөөллийн ажил зохион байгуулсан байна. | Зөвлөмжийг хэрэгжүүлсэн ААН, гудамж, хороо, айл өрхийг олон нийтэд сурталчилсан байна. | АӨСҮТ НЭМҮТ | АНЗДТГ | Эрүүл мэндийг дэмжих сан<br><br>10.0 |
| 1.1.2 | Улаанбаатар хот болон аймгуудын ногоон байгууламжид байгаа харшил үүсгэгч ургамлын жагсаалтыг гаргаж, тайрах, харшил үүсгэхгүй үрслүүлэх | | Аргачлалыг боловсруул-сан байна. | Орон нутгийн шийдвэр гаргагчдад ухуулга нөлөөллийн ажил зохион | Зөвлөмжийг хэрэгжүүлсэн ААН, гудамж, хороо, айл өрхийг олон нийтэд | АӨСҮТ НЭМҮТ | ШУА-ийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн АНЗДТГ | Аймаг, нийслэлийн төсөв<br><br>10.0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | технологийн аргачлал боловсруулан, батлуулж, орон нутгийн шийдвэр гаргагчдад ухуулга нөлөөллийн ажил зохион байгуулах | | | байгуулсан байна. | сурталчилсан байна. | | | |
| 1.1.3 | Агаарт түгээмэл тархацтай бүдүүн ширхэгт тоосонцор $PM_{10}$, нарийн ширхэгт тоосонцор $PM_{2.5}$-ыг багасгахад дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулах | | АНЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан байна. | Хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласан байна. | Хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласан байна. | ЭМЯ АНЗДТГ | НЭМҮТ | Хариуцах байгууллагын төсөв |
| 1.1.4 | ЕБС, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих хяналтын журамд хүнсний харшлаас сэргийлэх тухай асуудлыг судлан санал боловсруулах | | Журмын төсөлд тусгах санал боловсруулсан байна. | Батлагдсан журмыг ЕБС, цэцэрлэгт таниулах МСС ажлыг зохион байгуулсан байна. | Журмын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлсэн байна. | ЭМЯ НЭМҮТ | БШУЯ ХХААХҮЯ МХЕГ | ОУБ |
| 1.1.5 | Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих стандартын (MNS 6648:2016) хэрэгжилтийн судалгаа хийх | | Хамтарсан ажлын хэсэг байгуулж, үнэлгээг гүйцэтгэн, зөвлөмж гаргана. | Үнэлгээний зөвлөмжийг ААН байгуулагад таниулах МСС ажлыг зохион байгуулна. | Хамтарсан ажлын хэсэг байгуулж, үнэлгээг гүйцэтгэн, зөвлөмж гаргана. | НЭМҮТ МХЕГ | ШӨХЭАХГ | Эрүүл мэндийг дэмжих сан<br><br>20.0 |
| 1.1.6 | Нийтийн хоолны газруудын хоолны жор, хоолны цэсэнд харшил төрүүлэгчийн агууламж, мэдээлж буй байдлыг тандах судалгаа хийж, зөвлөмж боловсруулах | | Судалгаа хийж, зөвлөмж гаргана. | Зөвлөмжийг сурталчлан, бодлогын шийдвэр болгох чиглэлээр ухуулга | Зөвлөмжийг хэрэгжүүлэх хамтарсан шийдвэр гарсан байна. | ЭМЯ | Сонгосон судалгааны баг | Эрүүл мэндийг дэмжих сан<br><br>20.0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | нөлөөлийн ажил зохион байгуулна. | | | | |
| **Үйл ажиллагааны чиглэл 1.2.** Харшлын өвчний оношилгоо, эмчилгээг сайжруулахад чиглэсэн бодлого, эрх зүйн орчинг бүрдүүлж сайжруулах | | | | | | | | |
| 1.2.1 | Харшлын арьс хатгах, арьс бигнэх сорилын үйлдлийн стандартыг боловсруулж, батлуулах | Арьс хатгах үйлдлийн стандарт батлагдсан байна. | Арьс бигнэх үйлдлийн стандарт батлагдсан байна. | Стандартыг таниулах цахим сургалтын хөтөлбөр боловсруул-сан байна. | Эрүүл мэндийн ажилтанд сургалт зохион байгуулсан байна. | ЭМЯ МСЗ | МХСН АӨСҮТ | Хариуцах байгууллагын төсөв |
| 1.2.2 | Харшлын арьсан дотор тарих сорилын аргачлалыг боловсруулах | Төсөл боловсруул-сан байна. | Стандартыг хэлэлцүүлж, батлуулсан байна. | Стандартыг таниулах цахим сургалтын хөтөлбөр боловсруул-сан байна. | Эрүүл мэндийн ажилтанд сургалт зохион байгуулсан байна. | ЭМЯ АӨСҮТ | МСЗ | Хариуцах байгууллагын төсөв |
| 1.2.3 | Гуурсан хоолойн багтрааны спирометрийн оношилгооны үйлдлийн стандартыг боловсруулж, батлуулах | Төсөл боловсруул-сан байна. | Стандартыг хэлэлцүүлж, батлуулсан байна. | Стандартыг таниулах цахим сургалтын хөтөлбөр боловсруулсан байна. | Эрүүл мэндийн ажилтнуудад сургалт зохион байгуулсан байна. | ЭМЯ МСЗ | МХСН | Хариуцах байгууллагын төсөв |
| 1.2.4 | Харшлын шалтгаант ринитийн эмнэлзүйн зааврыг боловсруулж, батлуулах | | Эмнэлзүйн зааврыг боловсруулж, ЭМС-ын тушаалаар батлуулсан байна. | Зааврыг таниулах цахим сургалтын хөтөлбөр боловсруул-сан байна. | Эрүүл мэндийн ажилтнуудад сургалт зохион байгуулсан байна. | ЭМЯ МХСН | МСЗ | Хариуцах байгууллагын төсөв |
| 1.2.5 | Гуурсан хоолойн багтраа өвчний эмнэлзүйн зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулах | | Эмнэлзүйн зааврыг боловсруулж, ЭМС-ын тушаалаар | Зааврыг таниулах цахим сургалтын | Эрүүл мэндийн ажилтнуудад сургалт зохион | ЭМЯ МН (МУСН, МХСН) | МСЗ | Хариуцах байгууллагын төсөв |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | батлуулсан байна. | хөтөлбөр боловсруул-сан байна. | байгуулсан байна. | | | |
| 1.2.6 | Чонон хөрвөсийн эмнэлзүйн заавар боловсруулж батлуулах | | Эмнэлзүйн зааврыг боловсруулж, ЭМС-ын тушаалаар батлуулсан байна. | Зааврыг таниулах цахим сургалтын хөтөлбөр боловсруул-сан байна. | Эрүүл мэндийн ажилтанд сургалт зохион байгуулсан байна. | ЭМЯ АӨСҮТ | МСЗ МХСН | Хариуцах байгууллагын төсөв |
| 1.2.7 | Хавьтал дерматитын харшлын эмнэлзүйн заавар боловсруулж батлуулах | | Эмнэлзүйн зааврыг боловсруулж, ЭМС-ын тушаалаар батлуулсан байна. | Зааврыг таниулах цахим сургалтын хөтөлбөр боловсруул-сан байна. | Эрүүл мэндийн ажилтанд сургалт зохион байгуулсан байна. | ЭМЯ АӨСҮТ | МСЗ МХСН | Хариуцах байгууллагын төсөв |
| **Үйл ажиллагааны чиглэл 1.3.**<br>Харшлын өвчний эмнэлгийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй, чанартай болгоход чиглэсэн бодлого, эрх зүйн орчинг бүрдүүлж сайжруулах | | | | | | | | |
| 1.3.1 | Улсын хэмжээнд харшлын оношилгоо, эмчилгээ, сургалт, арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий Харшлын төвийг байгуулах | | ЭМС-ын тушаал боловсруулж, батлуулсан байна. | Харшлын төвийн хүний нөөц, багаж тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж төсөвт тусгасан байна. | Харшлын төвийн үйл ажиллагааг жигдрүүлж, сургалт зохион байгуулсан байна. | ЭМЯ | МСЗ | Хариуцах байгууллагын төсөв |
| 1.3.2 | Харшлын эмч бэлтгэх төрөлжсөн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх | | Сургалтын хөтөлбөрийг шинэчилсэн байна. | Шинэчилсэн хөтөлбөрөөр сургалт явуулж эхэлсэн байна. | Хөтөлбөрийн үр дүнг үнэлсэн байна. | ЭМХТ МСЗ | АШУҮИС | Хариуцах байгууллагын төсөв |
| 1.3.3 | Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ-ийн эмнэлзүйн харшил судлалын | | Шинэчлэгдсэн хөтөлбөрөөр орон нутагт мэргэжилтэн | Мэргэшүүлэх сургалтад хамруулсан байна. | Эмнэлзүйн харшил судлалын эмчийг орон | ЭМБ ЭМХТ | АНЭМГ | Сургалтын Төрийн сан |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | эмчийг орон тоогоор ажиллуулах | | бэлтгэсэн байна. | | тоогоор ажиллуулсан байна. | | | |
| 1.3.4 | Өрх, хүүхэд, чих хамар хоолой, нүд, дотор судлалын үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөрт харшил судлалын хичээлийн агуулгыг шинэчлэн тусгах | | Сургалтын хөтөлбөрийг шинэчилсэн байна. | Шинэчилсэн хөтөлбөрөөр сургалт явуулж эхэлсэн байна. | Хөтөлбөрийн үр дүнг үнэлсэн байна. | ЭМХТ МСЗ | АШУҮИС | Хариуцах байгуул-лагын төсөв |
| 1.3.5 | Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр, төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөлтийн жагсаалтад харшлын хяналтын эмчилгээний эм, гадуур хэрэглэх тосон түрхлэг оруулах | | ЭМД-ын үнийн хөнгөлөлт үзүүлэх шаардлагатай шинээр оруулах харшлын эмийг судалсан байна. | ЭМД-ын үнийн хөнгөлөлт үзүүлэх жагсаалтад шинээр оруулах эмийн талаар үндэслэл, эдийн засгийн тооцоог хийсэн байна. | ЭМДҮЗ-д шинээр оруулах эмийн талаар санал боловсруулж хүргүүлсэн байна. | ЭМДЕГ ЭЭХХЗГ | ЭМЯ | Хариуцах байгуул-лагын төсөв |
| **Зорилт 2.**<br>**Харшлын эрсдэлт хүчин зүйлсийг бууруулж, хүн амын мэдлэгийг дээшлүүлэх** | | | | | | | | |
| **Үйл ажиллагааны чиглэл 2.1.**<br>Харшил, харшлын өвчний эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах, хүндрэлээс сэргийлэх | | | | | | | | |
| 2.1.1 | "Харшлаас урьдчилан сэргийлэх" салбар дундын зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, уриалга боловсруулах | | Салбар дундын зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, удирдамжийг боловсруул-сан байна. | Уриалгыг аймаг, дүүрэг бүрт хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байна. | Уриалгыг аймаг, дүүрэг бүрт хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байна. | ЭМЯ НЭМҮТ | АНЭМГ АНЗДТГ | ОУБ |
| 2.1.2 | Ногоон байгууламж дах харшил үүсгэгч ургамлыг тоос, үр боловсрохоос өмнө батлагдсан аргачлалын | | Орон нутгийн шийдвэр гаргагч нарт ухуулга | Тайралт зөв хийсэн хот тохижуулах байгууллага, | Тайралт зөв хийсэн хот тохижуулах байгууллага, | АӨСҮТ НЭМҮТ | АНЗДТГ | Аймаг, нийслэ-лийн төсөв |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дагуу тайралт хийх ажлыг зохион байгуулахад ухуулга нөлөөллийн ажлыг зохион байгуулах | | нөлөөллийн ажлыг зохион байгуулсан байна. | СӨХ, баг хороог сурталчлах ажлыг зохион байгуулсан байна. | СӨХ, баг хороог сурталчлах ажлыг зохион байгуулсан байна. | | | 10.0 |
| 2.1.3 | Дотоод орчинд харшил үүсгэгч (агаарын бохирдол, дам тамхидалт, хөгц мөөгөнцөр гэх мэт) хүчин зүйлсийг тодорхойлж үнэлэх, зөвлөмж боловсруулах, хүн амд түгээх | | Үнэлгээ хийх аргачлал боловсруулж батлуулан үнэлгээ хийгдсэн байна. | Үнэлгээний тайлан гарч үр дүнг шийдвэр гаргагч нарт танилцуулсан байна. | Үнэлгээний үр дүнг хэвлүүлж түгээсэн байна. | НЭМҮТ | МХЕГ | Эрүүл мэндийг дэмжих сан 40.0 |
| 2.1.4 | Суурьшлын бүсийн сул шороон хөрсийг харшил үүсгэдэггүй зөвшөөрөгдсөн ургамлаар зүлэгжүүлж, харшлын эрсдэлт хүчин зүйлийг бууруулах ухуулга нөлөөллийн ажлыг зохион байгуулах | | Орон нутгийн шийдвэр гаргагч нарт ухуулга нөлөөллийн ажлыг зохион байгуулсан байна. | Аймаг нийслэлийн Засаг даргатай хийх гэрээнд тусган хэрэгжүүлсэн байна. | Аймаг нийслэлийн Засаг даргатай хийх гэрээнд тусган хэрэгжүүлсэн байна. | НЭМҮТ | АӨСҮТ АНЗДТГ | Эрүүл мэндийг дэмжих сан 10.0 |
| 2.1.5 | ЕБС-ийн эрүүл мэндийн хичээлийн багш нарт харшлын өвчнөөс сэргийлэх, эрсдэлийг бууруулах сэдвээр чадавхижуулах сургалт зохион байгуулах | | Чадавхижуу-лах сургалтын хөтөлбөр, агуулга бэлэн болсон байна. | ЕБС-ийн эрүүл мэндийн багш нарт сургалт зохион байгуулж, үр дүнг тооцсон байна. | ЕБС-ийн эрүүл мэндийн багш нарт сургалт зохион байгуулж, үр дүнг тооцсон байна. | НЭМҮТ АӨСҮТ | БШУЯ АШУҮИС | Аймаг, нийслэлийн төсөв 50.0 |
| 2.1.6 | Хүнсний бүтээгдэхүүний сав, баглаа боодлын шошгололтод харшил үүсгэдэг орц бүрдүүлэгчийг зөв таних, шошгын тэмдэглэгээний талаар олон нийтэд чиглэсэн МСС ажлыг зохион байгуулах | | Хамтарсан ажлын хэсэг байгуулж, МСС-ны үндсэн агуулгыг боловсруулсан байна. | МСС-ны бүтээгдэхүүнийг олон нийтийн сүлжээгээр идэвхтэй түгээсэн байна. | МСС-ны үр дүнг тооцох судалгаа хийсэн байна. | НЭМҮТ | ХХААХҮЯ МХЕГ | Эрүүл мэндийг дэмжих сан 15.0 |
| 2.1.7 | Амьтны харшил, түүнээс сэргийлэх зөвлөмж | | Зөвлөмж, МСС-ны | Зөвлөмжийг олон нийтийн | - | МХСН | НЭМҮТ АНЗДТГ | Эрүүл мэндийг |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулж, мал эмнэлэг, амьтны дэлгүүрийг хангасан байна. | | бүтээгдэхүүн боловсруулж түгээсэн байна. | сүлжээгээр хүн амд түгээсэн байна. | | | | дэмжих сан<br>10.0 |
| 2.1.8 | Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, жороор эм олголтыг сайжруулах | | Харшлын эмийн жор бичилтийн тандалт судалгааг хийж, дүгнэлт хийж, үр дүнг үнэлэх | Гарсан үр дүн, тайлангаас хамаарч харшлын эмийн жор бичилтэд зөвлөмж боловсруулах, хяналт тавьж ажиллах | Жороор эм олголтын тогтолцоог бий болгох | ЭЭХХЗГ МХЕГ | ЭМЯ | Хариуцах байгууллагын төсөв |
| **Үйл ажиллагааны чиглэл 2.2.**<br>Харшлаас урьдчилан сэргийлэх талаар хүн амын дунд мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх, олон нийтийн санаачилгыг дэмжих | | | | | | | | |
| 2.2.1 | Харшлын Дэлхийн 7 хоногийг тэмдэглэн өнгөрүүлэх | | Жил бүр тэмдэглэсэн байна. | Жил бүр тэмдэглэсэн байна. | Жил бүр тэмдэглэсэн байна. | МХСН | НЭМҮТ АӨСҮТ | ОУБ |
| 2.2.2 | Эмийн харшлаас сэргийлэх, антибиотикийн хэрэглээг зөв зохистой болгох мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагааг зохион байгуулах | | Хүн амын мэдлэгийг тандах цахим судалгаа хийсэн байна. | Цахим судалгааны дүнг үндэслэн МСС-ны бүтээгдэхүүн боловсруулж түгээсэн байна. | МСС-ны үйл ажиллагааны үр дүнг тооцсон байна. | ЭЭХХЗГ | НЭМҮТ МХСН | ОУБ |
| 2.2.3 | Харшлын талаар цогц мэдээлэл зөвлөгөө өгөх цахим ба нүүр номны хуудас ажиллуулах | | НЭМҮТ-ийн цахим хуудас харшлын булантай болсон байна. | Харшлын цахим хуудасны мэдээллийг түгээх нүүр номны хуудастай болсон байна. | Цахим хуудас, нүүр номны хуудасны үйл ажиллагаа тогтмолжсон байна. | НЭМҮТ | МХСН | Эрүүл мэндийг дэмжих сан<br>25.0 |
| 2.2.4 | Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд | | Сургалтын хөтөлбөр | Сургалтыг бүсчлэн | Сургалтыг бүсчлэн | НЭМҮТ | ХХААХҮЯ | Эрүүл мэндийг |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | харшил үүсгэгч хүнсний бүтээгдэхүүн, шошго, тэмдэг, тэмдэглэгээний талаар сургалт зохион байгуулах | | агуулгыг боловсруулах | зохион байгуулах, үр дүнг тооцох | зохион байгуулах, үр дүнг тооцох | | | дэмжих сан 15.0 |
| 2.2.5 | Харшил төрүүлэгч ургамлын агаар дахь тоосжилтын хуанлийг боловсруулж, өдөр тутмын цаг агаарын мэдээнд оруулдаг болгох | | - Хамтарсан ажлын хэсэг байгуулсан байна.<br>- Хуанли боловсруулсан байна. | - Цаг агаарын мэдээлэлд оруулах бэлтгэлийг хангасан байна.<br>- Цаг агаарын мэдээнд оруулж хэвшсэн байна. | Мэдээлэл тогтворжсон байна. | ЭМЯ АӨСҮТ | БОАЖЯ Цаг уур орчны шинжилгээ-ний газар | Эрүүл мэндийг дэмжих сан<br><br>20.0 |
| **Зорилт 3.**<br>**Харшлын өвчний оношилгоо, эмчилгээний менежментийг боловсронгуй болгож, хүндрэлийг бууруулах** | | | | | | | | |
| **Үйл ажиллагааны чиглэл 3.1.**<br>Харшил, харшлын шалтгаант өвчлөлийн оношилгооны чадамжийг сайжруулан, лабораторийг бэхжүүлэх | | | | | | | | |
| 3.1.1. | Харшлын шалтгааныг тогтоох аллерген-өвөрмөц IgE тодорхойлох Монгол Улсын панел бий болгох, нэвтрүүлэх | | Монгол улсад түгээмэл тохиолддог аллергенийг тогтоосон байна. | Панелыг захиалах, оношлогоонд нэвтрүүлсэн байна. | Шинэ оношилгоо нутагшсан байна. | ЭМЯ ЭЭХХЗГ | МХСН ЭМБ | Улсын төсөв<br><br>10.0 |
| 3.1.2 | Гуурсан хоолойд өдөөх сорилын (метахолинтой, дасгалаар өдөөх) зааврыг үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт нэвтрүүлэх | | Гуурсан хоолойд өдөөх сорилын зааврыг батлуулан сургалт зохион байгуулсан байна. | Шинэ сорилыг нэвтрүүлж эхэлсэн байна. | Үр дүнг тооцох технологийг нутагшуулсан байна. | ЭМЯ МСЗ | ЭМБ | Хариуцах байгууллагын төсөв |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.3 | Анафилаксийн шокийн үед яаралтай тусламж үзүүлэх талаар боловсролын байгууллагын эмч нарт сургалт зохион байгуулах | | Яаралтай тусламжийн сургалтын хөтөлбөр видео контент боловсруул сан байна. | Нийслэлийн сургуулийн эмч нарт сургалт зохион байгуулсан байна. | Аймгийн сургуулийн эмч нарт сургалт зохион байгуулсан байна. | УНТЭ МСЗ | МХСН АӨСҮТ | ОУБ |
| **Үйл ажиллагааны чиглэл 3.2.**<br>Харшил, харшлын өвчний эмчилгээний менежментийг сайжруулах, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн чадавхийг бэхжүүлэх | | | | | | | | |
| 3.2.1 | Атопийн дерматитын хяналтын зааврыг боловсруулах, хүндрэл сэдрэлээс сэргийлэх | | Хяналтын карт, бичгээр үйлдсэн үйлдлийн төлөвлөгөө шинэчлэгдсэн байна. | Хяналтын заврын сургалт зохион байгуулсан байна. | Шинэчлэгдсэн хяналтын заавар бүрэн нэвтэрсэн байна. | ЭМЯ АӨСҮТ | МСЗ | Хариуцах байгуул-лагын төсөв |
| 3.2.2 | Багтраа өвчний хяналтын төлөвлөгөө боловсруулах, хүндрэл сэдрэлээс сэргийлэх | | Хяналтын төлөвлөгөө шинэчлэгдэн хэвлэгдсэн байна. | Хяналтын заврын сургалт зохион байгуулсан байна. | Шинэчлэгдсэн хяналтын заавар бүрэн нэвтэрсэн байна. | ЭМЯ УНТЭ | МСЗ | Хариуцах байгуул-лагын төсөв |
| 3.2.3 | Иргэн өөрөө өөрийгөө хянах атопийн дерматит, астмын менежментийн гар утасны аппликейшн боловсруулж, нэвтрүүлэх | | Өөрөө өөрийгөө хянах заавар шинэчлэгдэж, аппликейшн боловсруулах техникийн даалгавар бэлэн болсон байна. | Аппликейш-ныг туршиж нэвтрүүлсэн байна. | Аппликейшны хэрэглээ нэмэгдсэн байна. | ЭМЯ МСЗ | Сонгогд-сон гүйцэтгэгч | ОУБ |
| 3.2.4 | Харшлын шалтгаант өвчлөлийн цахим сургалтын модуль боловсруулах | | Цахим сургалтын хөтөлбөр, агуулгыг боловсруул-сан байна. | Цахим сургалтын хөтөлбөрийг төгсөлтийн дараах сургалтын | Цахим сургалтыг үзэж, багц цаг бүртгүүлсэн эмнэлгийн мэргэжилт- | ЭМЯ ЭМХТ | МСЗ АШУҮИС | Хариуцах байгуул-лагын төсөв |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | багц цагтай холбон цахим платформд байршуулсан байна. | нүүд нэмэгдсэн байна. | | | |
| 3.2.5 | Харшлын өвчний эмнэлзүйн заавруудыг багтаасан цахим болон хэвлэмэл гарын авлага хэвлэж, тараах | | Цахим сан үүсгэсэн байна. | Гарын авлагыг хэвлэж тараасан байна. | | ЭМЯ АӨСҮТ | НЭМҮТ | Эрүүл мэндийг дэмжих сан 10.0 |
| 3.2.6 | Өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмч нарыг харшлын өвчний цогц менежментийн сургалтад хамруулах | | | Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарыг сургасан байна. | Сумын эрүүл мэндийн төвийн эмч нарыг сургасан байна. | ЭМХТ | АНЭМГ Мэргэж-лийн нийгэм-лэгүүд | Хариуцах байгуул-лагын төсөв |
| 3.2.7 | Харшлын төрөлжсөн мэргэшлийн эмч нарыг гадаадын өндөр хөгжилтэй улс оронд богино хугацааны сургалт, олон улсын хурал зөвлөгөөнд оролцоход дэмжлэг үзүүлэх | | Сургалтын хэрэгцээ, чиглэл, хөтөлбөрийг судлаж, санхүүжил-тийг шийдвэрлүүл-сэн байна. | Сургалтанд хамруулах мэргэжилт-нийг сонгох, гэрээ байгуулж сургасан байна. | Сургалтын үр дүнг тооцож, шинэ мэдлэгийг түгээх цахим сургалт зохион байгуулсан байна. | МХСН | ЭМЯ | Хариуцах байгуул-лагын төсөв<br><br>ОУБ |
| **Зорилт 4.**<br>**Харшлын өвчлөлийн тандалт судалгааг эрчимжүүлж, нотолгоонд суурилсан мэдээллийн сантай болох** | | | | | | | | |
| **Үйл ажиллагааны чиглэл 4.1.**<br>Харшлын өвчлөлийн тархалтын суурь судалгааг эрчимжүүлэх | | | | | | | | |
| 4.1.1 | Улаанбаатар хотын 6-7 насны хүүхдийн дунд харшлын өвчний тархалтын олон улсын (ISAAC) аргачлалаар судалгаа хийх | | Тархалтын судалгаа хийсэн байна. | Судалгааны тайлан гарч үр дүнг шийдвэр гаргагч нарт танилцуулсан. | Судалгааны үр дүнг хэвлүүлж түгээсэн байна. | ЭМЯ | Судалгаа ны баг | Эрүүл мэндийг дэмжих сан<br><br>40.0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.2 | Атопийн дерматитын эрсдэлт хүчин зүйлс, тархвар зүйн үндэсний судалгаа хийх | | Тархалтын судалгаа хийсэн байна. | Судалгааны тайлан гарч үр дүнг шийдвэр гаргагч нарт танилцуулсан байна. | Судалгааны үр дүнг хэвлүүлж түгээсэн байна. | ЭМЯ | Судалгаа-ны баг | Эрүүл мэндийг дэмжих сан<br>50.0 |
| 4.1.3 | Атопийн дерматитын эмнэл зүй, хүндрэлийн судалгаа хийх | | Тархалтын судалгаа хийсэн байна. | Судалгааны тайлан гарч үр дүнг шийдвэр гаргагч нарт танилцуулсан байна. | Судалгааны үр дүнг хэвлүүлж түгээсэн байна. | ЭМЯ | Судалгаа-ны баг | Эрүүл мэндийг дэмжих сан<br>50.0 |
| 4.1.4 | Харшлын шалтгаант амьсгалын замын архаг өвчнүүдийн тархалтын үндэсний судалгаа хийх | | Тархалтын судалгаа хийсэн байна. | Судалгааны тайлан гарч үр дүнг шийдвэр гаргагч нарт танилцуулсан байна.. | Судалгааны үр дүнг хэвлүүлж түгээсэн байна | ЭМЯ | Судалгаа-ны баг | Эрүүл мэндийг дэмжих сан<br>45.0 |
| 4.1.5 | Харшлын талаарх хүн амын мэдлэгийн түвшин тогтоох цахим судалгаа хийх | | Суурь судалгаа хийсэн байна. | | Давтан судалгаа хийсэн байна. | ЭМЯ | Судалгаа-ны баг | Аймаг, нийс-лэлийн төсөв<br>20.0 |
| **Үйл ажиллагааны чиглэл 4.2.**<br>Харшлын өвчлөлийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх | | | | | | | | |
| 4.2.1 | Харшлын өвчлөлийг бүртгэж, мэдээлж байгаа өнөөгийн байдлыг үнэлэх | | - Үнэлгээ хийж, зөвлөмж гаргасан байна.<br>- Үнэлгээний үр дүнг шийдвэр гаргагчдад | | | ЭМХТ | ЭМЯ | Аймаг, нийс-лэлийн төсөв<br>10.0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | танилцуулсан байна. | | | | | |
| 4.2.2 | Харшлын өвчлөлийн бүртгэл, статистик мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох | | | Үнэлгээний үр дүнд үндэслэн харшлын өвчнийг бүртгэх тайлагнах маягт, журмыг шинэчилсэн байна. | Шинэчлэгдсэн маягтын дагуу программ хангамжид өөрчлөлт оруулсан байна. | ЭМХТ | ЭМБ | Хариуцах байгуул-лагын төсөв |

**Яамд**

БОАЖЯ-Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БШУЯ-Боловсрол, шинжлэх ухааны яам
ХХААХҮЯ-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ЭМЯ-Эрүүл мэндийн яам
ОУБ-Олон улсын байгууллага

**Засгийн газрын агентлаг, бусад байгууллага**

АӨСҮТ- Арьсны өвчин судлалын үндэсний төв
АШУҮИС-Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
ЕБС-Ерөнхий боловсролын сургууль
МХЕГ-Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МХСН-Монголын харшил судлалын нийгэмлэг
МСЗ-Мэргэжлийн салбар зөвлөл
НЭМҮТ-Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
УНТЭ-Улсын нэгдүгээр төв эмнэлэг
ЭМБ-Эрүүл мэндийн байгууллагууд
ЭМХТ-Эрүүл мэндийн хөгжлийн төв
ЭЭХХЗГ-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын гзар
ШУА-Шинжлэх ухааны академи

**Орон нутгийн засаг захиргааны байгууллага**

АНЗДТГ-Аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газар
АНЭМГ-Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар

АЗДТГ-Аймгийн засаг даргын тамгын газар

**Төрийн бус байгууллага болон бусад**

ААН-Аж ахуй нэгж

ОУБ-Олон улсын байгууллага

ТББ-Төрийн бус байгууллага

Эрүүл мэндийн сайдын 2021 оны
12 дугаар сарын 31 өдрийн А/816 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

## “ХАРШЛААС СЭРГИЙЛЭХ” АРГА ХЭМЖЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

| № | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин 2021 | Хүрэх түвшин (оноор) | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 2022 | 2023 | 2024 |
| | **Үр дүнгийн шалгуур үзүүлэлт** | | | | |
| 1. | Харшил, харшлын өвчний талаарх хүн амын мэдлэгийн түвшин сайжирна | Мэдээлэл байхгүй | Суурь судалгаа хийгдсэн байна | | Үнэн зөв мэдээлэлтэй хүн амын эзлэх хувь суурь түвшинтэй харьцуулахад 20-30% нэмэгдэнэ |
| | **Үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт** | | | | |
| 2. | Харшил судлалын чиглэлээр зохион байгуулагдсан сургалтын тоо (2024 онд өссөн дүнгээр) | Мэдээлэл байхгүй | 4 | 6 | 8 |
| 3. | Харшил судлалын хичээлийн агуулгыг шинэчлэн тусгасан үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийн тоо (2024 онд өссөн дүнгээр) | 2 | 2 | 3 | 5 |
| 4. | Олон нийтэд чиглэсэн харшлын талаарх үндэслэл нотолгоо бүхий веб ба нүүр номын хуудасны хоногийн хандалтын тооны өсөлт | Мэдээлэл байхгүй | Нүүр хуудас ажиллуулж эхэлсэн байна | Нүүр хуудасны хандалтын тоо эхэлснээс хойш 10%-иар нэмэгдсэн | Жил тутамд 20-30% |
| 5. | Судалгаанд хамрагдсан хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод харшил төрүүлэгчийн орц бүрдүүлэгчийг | Мэдээлэл байхгүй | | | Судалгааны тайлан гарч олон нийтэд |

| № | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин 2021 | Хүрэх түвшин (оноор) | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 2022 | 2023 | 2024 |
| | мэдээлсэн бүтээгдэхүүний эзлэх хувийн өсөлт | | | | мэдээлсэн байна. |
| 6. | Атопийн дерматит, астматай өөрийгөө хянах төлөвлөгөөг хэрэгжүүлдэг үйлчлүүлэгчийн тоо | Мэдээлэл байхгүй | Өөрийгөө хянадаг төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлсэн байна. | Хяналтанд буй үйлчлүүлэгчийн 30% хэрэглэдэг болсон байна. | Хяналтанд буй үйлчлүүлэгчийн 60% хэрэглэдэг болсон байна. |
| 7. | Харшлын өвчлөл, хүндрэлийн мэдээлэл эрүүл мэндийн үзүүлэлтийн жил бүрийн товхимолд тусгагдсан байх | Мэдээлэл байхгүй | | Харшлын өвчлөл, хүндрэлийн мэдээлдэг болсон байна | |
| 8. | Шинэчлэн боловсруулсан заавар, үйлдлийн стандарт, аргачлалын тоо | 2 | 2 | 4 | 8 |
| 9. | Харшлын чиглэлээр хийгдсэн судалгааны тайлан, хэвлүүлсэн өгүүллийн тоо (2024 онд өссөн дүнгээр) | Мэдээлэл байхгүй | - Тайлан 1<br>- Өгүүлэл 1 | - Тайлан 4<br>- Өгүүлэл 9 | - Тайлан -5<br>- Өгүүлэл- 10 |